

БАТЛАВ  
САНГИЙН САЙД



Б.ЖАВХЛАН

БАТЛАВ  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

  
О.АЛТАНГЭРЭЛ

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН  
2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр баталгаажуулсан байгалийн баялаг, түүний дотор газрын хэвлийн баялгийг ашиглах суурь зарчим, нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас бий болсон үр өгөөжийг өнөө ба хойч үеийн иргэн бүрд тэнцвэртэй хуваарилах үзэл санааг хэрэгжүүлэх зорилготой Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр батлагдан, хүчин төгөлдөр хэрэгжиж эхлээд байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Баялгийн сангийн төсөв нь нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.” гэж, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.58 дахь заалтад ““Үндэсний баялгийн сангийн төсөв” гэж Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагуу төрөлжсөн сан бүрд төвлөрүүлж, зарцуулах, хуримтлал үүсгэх зорилгоор тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг” гэж, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж тус тус заасан нь Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Сүүлийн 30 жилийн хугацааны үзүүлэлтээс үзвэл Монгол Улсын нийгэм, эдийн засаг нь байгалийн баялаг, түүний дотор газрын хэвлийн баялаг, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын нөөц ашигласны үр өгөөжөөс ихээхэн хамааралтай болох нь харагддаг. Тодруулбал, эрдэс баялгийн салбарын орлого нь

2020 онд Монгол Улсын нэгдсэн төсвийн 25.7 хувийг<sup>1</sup>, 2021 онд 28.9 хувийг<sup>2</sup>, 2022 онд 35.1 хувийг, 2023 онд 33.3 хувийг тус тус бүрдүүлж байв.

Эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрөх орлогыг одоо ба ирээдүйн иргэдэд тэгш хүртээх, хуваарилах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас өмнө нь тухайлсан нэг сантай холбогдох харилцааг зохицуулах зорилготой хууль тогтоомж буюу Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хууль, Хүний хөгжил сангийн тухай хууль болон Ирээдүйн өв сангийн тухай хуулийг тус тус баталж байсан бол энэ оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн гурван төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоог бий болгоод байна.

Иймээс Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд эх үүсвэр төвлөрүүлэх, хуримтлал үүсгэх болон эдгээртэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийг боловсруулан, батлуулах шаардлагатай байна.

**Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл 2 бүлэгтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн хууль тогтоомжийн талаар;

Хоёрдугаар бүлэгт Үндэсний баялгийн санд 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээ, хуримтлуулах хэмжээ болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар**

Хуулийн төсөл батлагдсанаар Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд орлого төвлөрүүлж, хуримтлуулан Үндэсний баялгийн сангаар дамжуулан байгалийн баялгийг хуваарилах Үндсэн хуулийн суурь зарчим хангагдана.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар**

<sup>1</sup>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрдэс баялгийн салбарын статистик мэдээлэл (2020 - I-XII), 1 дэх тал.

<sup>2</sup>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрдэс баялгийн салбарын статистик мэдээлэл (2021, I-XII), 2 дахь тал.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл байхгүй болно.

---о0о---